



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 5/23

Модот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг улсын чанартай замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, гарч болзошгүй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүний амь нас эрүүл мэндэд хөрөнгөнд учирч болох хохирлыг бууруулах зорилгоор мэдээлэл самбарыг байршуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2.Мэдээлэл самбарын стандарт хэмжээ, тодорхой батлагдсан цэгт байршуулах ажлыг сумын хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахлах дэслэгч (Б.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

3. Уг арга хэмжээний зардлыг сумын Засаг даргын нөөц сангаас 1500000 (Нэг сая таван мянган төгрөг)-ийг Санхүү албаны нягтлан бодогч (О.Батбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЗОЛЖАРГАЛ